

# ХААН СОЁМБО АУДИТ ХХК



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/43/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Хөвсгөл аймаг  
2022 он

Аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар  
Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр  
Утас: 99089114 Цахим хаяг: [tegshdelgerb@audit.gov.mn](mailto:tegshdelgerb@audit.gov.mn)

Ахлах аудитор: Б.Давааням  
Утас: 92113932 Цахим хаяг: [davaanyamb@audit.gov.mn](mailto:davaanyamb@audit.gov.mn)

Хаан соёмбо аудит ХХК-ын захирал: Х.Диймаа  
Утас: 99065668 Цахим хаяг: [info@khaansoyomboaudit.mn](mailto:info@khaansoyomboaudit.mn)

Гүйцэтгэсэн аудитор: Н.Бадамханд  
Утас: 99042699 Цахим хаяг: [khaan.soyombo.audit@gmail.com](mailto:khaan.soyombo.audit@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
3. Аудитын тайлан .....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	11
3.2 Байгууллагын гадаад дотоод орчин .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	13
4.1 Ерөнхий зүйл .....	13
4.2 Материаллаг байдал .....	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
4.5.1 Завсрын аудитын талаар .....	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	14
4.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	14
4.8 Аудитын гол асуудал .....	14
4.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
4.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	15
4. Аудитын илрүүлэлт .....	15
4.1 Залруулсан алдаа .....	15
4.2 Төлбөрийн акт .....	15
4.3 Албан шаардлага .....	15
4.4 Зөвлөмж .....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	15

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2023.02.15 № 01/66  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ГЭР БҮЛ,  
ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН  
ГАЗРЫН ДАРГА Ч.ДАШБАЯР ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

“Хүүхэд харах үйлчилгээний төв” байгуулахаар 490.0 сая төгрөгийн анхны өртөгтэй сургуулийн байр шилжүүлж авсан байна.

### Аудитын гол асуудал

Өмнөх оны авлага 1.8 сая төгрөгийн авлага барагдуулаагүй, тайлант онд буураагүй, өр төлбөрийг 78.9 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

### Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2022 онд 2 зорилтын хүрээнд 46 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж ажилласнаас 90.8 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЗБААТАР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>42,683,394.80</b>	<b>62,894,998.00</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	1,829,703.00	1,829,703.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	860,812.00	860,812.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	968,891.00	968,891.00
3351	Байгууллагаас авах авлага	968,891.00	968,891.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	40,853,691.80	61,065,295.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	155,321.80	12,400.00
35130	Эм боох материал	155,321.80	12,400.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	40,698,370.00	61,052,895.00
35420	Аж ахуйн материал	22,190,633.00	22,965,008.00
35470	Бусад хангамжийн материал	18,507,737.00	38,087,887.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,320,459,494.70</b>	<b>2,860,420,718.18</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	2,320,459,494.70	2,860,420,718.18
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	2,257,428,494.70	2,713,872,634.85
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,271,808,260.00	2,762,577,215.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-113,786,431.20	-158,347,254.48
39203	Авто-тээврийн хэрэгсэл	25,000,000.00	25,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-12,499,999.92	-16,666,666.56
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	112,263,653.57	133,888,653.57
39206	Хуримтлагдсан элэгдэл	-33,064,715.47	-72,465,201.56
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	56,745,446.00	91,629,205.76
39208	Хуримтлагдсан элэгдэл	-49,037,718.28	-51,743,316.88
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	63,031,000.00	146,548,083.33
39301	Программ хангамж	961,000.00	6,956,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-550,000.00	-622,916.67
39303	Бусад биет бус хөрөнгө	62,620,000.00	140,215,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,363,142,889.50</b>	<b>2,923,315,716.18</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>6,173,659.96</b>	<b>78,969,208.80</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	6,173,659.96	78,969,208.80
<b>413</b>	<b>Өглөг</b>	6,173,659.96	78,969,208.80
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	6,173,659.96	78,969,208.80
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,356,969,229.54</b>	<b>2,844,346,507.38</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	2,356,969,229.54	2,844,346,507.38
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	130,629,021.00	208,224,021.00
51101	Өмч: - төрийн	130,629,021.00	208,224,021.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	1,016,352,509.23	1,426,134,787.07
51210	Өмнөх үеийн үр дүн	1,016,352,509.23	1,016,352,509.23
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	409,782,277.84
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,209,987,699.31	1,209,987,699.31
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,363,142,889.50</b>	<b>2,923,315,716.18</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>620,735,922.20</b>	<b>1,510,919,807.76</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>82,263,522.20</b>	<b>535,835,239.76</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	82,263,522.20	535,835,239.76
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	82,263,522.20	535,835,239.76
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	82,263,522.20	535,835,239.76
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>538,472,400.00</b>	<b>975,084,568.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	296,519,400.00	677,737,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	296,519,400.00	677,737,300.00

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	90,460,000.00	297,347,268.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	78,650,000.00	267,571,345.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	11,810,000.00	29,775,923.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	151,493,000.00	00.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	151,493,000.00	00.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>604,921,208.85</b>	<b>1,101,137,529.92</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>604,921,208.85</b>	<b>1,101,137,529.92</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	596,694,027.03	1,065,637,091.22
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	144,358,118.00	219,439,955.00
210101	Үндсэн цалин	115,636,620.70	178,458,979.00
210102	Нэмэгдэл	28,721,497.30	24,534,476.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	16,446,500.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	18,577,076.08	27,458,396.30
210201	Тэтгэврийн даатгал	12,867,419.90	18,671,711.73
210202	Тэтгэмжийн даатгал	1,427,415.15	2,196,670.30
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,141,932.08	1,757,336.12
210204	Ажилгүйдлийн даатгал	285,483.07	439,334.18
210205	Эрүүл мэндийн даатгал	2,854,825.88	4,393,343.97
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	153,539,101.06	230,231,609.84
210301	Гэрэл, цахилгаан	4,855,521.00	5,153,047.00
210302	Түлш, халаалт	143,171,180.96	215,777,724.84
210303	Цэвэр, бохир ус	5,512,399.10	9,300,838.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	9,348,694.00	7,898,860.00
210401	Бичиг хэрэг	3,422,400.00	2,461,520.00
210402	Тээвэр, шатахуун	3,313,330.00	2,709,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,393,864.00	1,803,440.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	66,000.00	203,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,153,100.00	721,200.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	4,860,000.00	6,619,440.00
210502	Хоол, хүнс	4,860,000.00	6,619,440.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	3,250,000.00	12,397,000.00
210604	Урсгал засвар	3,250,000.00	12,397,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,429,400.00	484,000.00
210702	Дотоод албан томилолт	1,429,400.00	484,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	199,163,146.00	467,458,638.80
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	197,793,959.00	465,234,974.80
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	540,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	54,400.00	22,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	55,962.00	55,962.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	00.00	54,450.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	399,000.00	1,309,300.00
210807	Газрын төлбөр	319,825.00	241,952.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	62,168,491.89	93,649,191.28
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,468,000.00	2,742,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	58,700,491.89	90,906,491.28
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	8,227,181.82	35,500,438.70
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,178,200.00	16,225,319.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	13,085,125.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,178,200.00	3,140,194.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	63,793.90	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,447.00	00.00

<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	6,985,187.92	19,275,119.70
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,985,187.92	19,275,119.70
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>15,814,713.35</b>	<b>409,782,277.84</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	1,728,000.00	00.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	1,728,000.00	00.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-1,728,000.00</b>	<b>00.00</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>14,086,713.35</b>	<b>409,782,277.84</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр /
					Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	130,629,021.00	1,209,987,699.31	1,042,503,827.38	2,383,120,547.69
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	130,629,021.00	1,209,987,699.31	1,042,503,827.38	2,383,120,547.69
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-40,238,031.50	-40,238,031.50
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	130,629,021.00	1,209,987,699.31	1,016,352,509.23	2,356,969,229.54
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	130,629,021.00	1,209,987,699.31	1,016,352,509.23	2,356,969,229.54
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	130,629,021.00	1,209,987,699.31	1,016,352,509.23	2,356,969,229.54
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	77,595,000.00	00.00	00.00	77,595,000.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	409,782,277.84	409,782,277.84
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	208,224,021.00	1,209,987,699.31	1,426,134,787.07	2,844,346,507.38

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>549,050,503.00</b>	<b>975,084,568.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>549,050,503.00</b>	<b>975,084,568.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	296,519,400.00	677,737,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>101,038,103.00</b>	<b>297,347,268.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	89,228,103.00	267,571,345.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	11,810,000.00	29,775,923.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>151,493,000.00</b>	<b>00.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	151,493,000.00	00.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>548,775,503.00</b>	<b>956,014,568.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>548,775,503.00</b>	<b>956,014,568.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>540,548,321.18</b>	<b>920,514,129.30</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>144,358,118.00</b>	<b>219,439,955.00</b>
210101	Үндсэн цалин	115,636,620.70	178,597,351.00

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210102	Нэмэгдэл	28,721,497.30	24,396,104.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	16,446,500.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>18,577,076.08</b>	<b>27,458,396.30</b>
210201	Тэтгэврийн даатгал	12,867,419.90	18,671,711.73
210202	Тэтгэмжийн даатгал	1,427,415.15	2,196,670.30
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,141,932.08	1,757,336.12
210204	Ажилгүйдлийн даатгал	285,483.07	439,334.18
210205	Эрүүл мэндийн даатгал	2,854,825.88	4,393,343.97
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>155,894,220.10</b>	<b>138,249,385.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,855,521.00	5,863,047.00
210302	Түлш, халаалт	145,526,300.00	123,085,500.00
210303	Цэвэр, бохир ус	5,512,399.10	9,300,838.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>10,815,764.00</b>	<b>7,898,860.00</b>
210401	Бичиг хэрэг	3,422,400.00	2,461,520.00
210402	Тээвэр, шатахуун	3,313,330.00	2,709,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,393,864.00	1,803,440.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	66,000.00	203,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,620,170.00	721,200.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>750,000.00</b>	<b>12,397,000.00</b>
210604	Урсгал засвар	750,000.00	12,397,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,429,400.00</b>	<b>484,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,429,400.00	484,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>199,555,743.00</b>	<b>511,843,833.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	198,186,556.00	509,620,169.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	540,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	54,400.00	54,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	55,962.00	55,962.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	00.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	399,000.00	1,309,300.00
210807	Газрын төлбөр	319,825.00	241,952.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>9,168,000.00</b>	<b>2,742,700.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,168,000.00	2,742,700.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>8,227,181.82</b>	<b>35,500,438.70</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,178,200.00</b>	<b>16,225,319.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	13,085,125.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,178,200.00	3,140,194.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>63,793.90</b>	<b>00.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,447.00	00.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>6,985,187.92</b>	<b>19,275,119.70</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,985,187.92	19,275,119.70
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>275,000.00</b>	<b>19,070,000.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>275,000.00</b>	<b>19,070,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>275,000.00</b>	<b>19,070,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>275,000.00</b>	<b>19,070,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	275,000.00	19,070,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-275,000.00</b>	<b>-19,070,000.00</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны / төгрөгөөр /		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	677,737,300.00	658,462,180.30	-19,275,119.7	97.2

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	677,737,300.00	658,462,180.30	-19,275,119.7	97.2
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	661,511,700.00	642,236,861.30	-19,274,838.7	97.1
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	233,188,100.00	219,439,955.00	-13,748,145.0	94.1
210101	Үндсэн цалин	192,720,900.00	178,597,351.00	-14,123,549.0	92.7
210102	Нэмэгдэл	23,010,200.00	24,396,104.00	1,385,904.0	106.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,457,000.00	16,446,500.00	-1,010,500.0	94.2
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	29,148,500.00	27,458,396.30	-1,690,103.7	94.2
210201	Тэтгэврийн даатгал	20,128,400.00	18,671,711.73	-1,456,688.3	92.8
210202	Тэтгэмжийн даатгал	2,255,000.00	2,196,670.30	-58,329.7	97.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,804,000.00	1,757,336.12	-46,663.9	97.4
210204	Ажилгүйдлийн даатгал	451,000.00	439,334.18	-11,665.8	97.4
210205	Эрүүл мэндийн даатгал	4,510,100.00	4,393,343.97	-116,756.0	97.4
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	132,664,700.00	132,389,097.00	-275,603.0	99.8
210301	Гэрэл, цахилгаан	4,831,500.00	4,555,897.00	-275,603.0	94.3
210302	Түлш, халаалт	123,085,500.00	123,085,500.00	0.0	100.0
210303	Цэвэр, бохир ус	4,747,700.00	4,747,700.00	0.0	100.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,764,400.00	3,737,140.00	-27,260.0	99.3
210401	Бичиг хэрэг	488,300.00	471,000.00	-17,300.0	96.5
210402	Тээвэр, шатахуун	2,046,900.00	2,046,700.00	-200.0	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,026,200.00	1,016,440.00	-9,760.0	99.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	203,000.00	203,000.00	0.0	100.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	502,300.00	484,000.00	-18,300.0	96.4
210702	Дотоод албан томилолт	502,300.00	484,000.00	-18,300.0	96.4
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	259,501,000.00	255,985,573.00	-3,515,427.0	98.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	258,478,800.00	254,970,661.00	-3,508,139.0	98.6
210803	Даатгалын үйлчилгээ	54,900.00	54,450.00	-450.0	99.2
210804	Тээврийн хэрэгслийн татвар	57,100.00	55,962.00	-1,138.0	98.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	27,700.00	22,000.00	-5,700.0	79.4
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	660,400.00	660,400.00	0.0	100.0
210807	Газрын төлбөр	222,100.00	222,100.00	0.0	100.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	274,270.00	274,270.00	0.0	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,742,700.00	2,742,700.00	0.0	100.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	16,225,600.00	16,225,319.00	-281.0	100.0
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	16,225,600.00	16,225,319.00	-281.0	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	13,085,400.00	13,085,125.00	-275.0	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,140,200.00	3,140,194.00	-6.0	100.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	677,737,300.00	658,462,180.30	-19,275,119.7	97.2
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	677,737,300.00	658,462,180.30	-19,275,119.7	97.2
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	677,737,300.00	658,462,180.30	-19,275,119.7	97.2
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	16.00	16.00	0.0	100.0
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	06.00	06.00	0.0	100.0
620003	Үйлчлэх ажилтан	09.00	09.00	0.0	100.0
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	06.00	06.00	0.0	100.0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	06.00	06.00	0.0	100.0

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	/ төгрөгөөр / Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>297,347,268.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>297,347,268.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	297,347,268.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	5,860,288.00
210301	Гэрэл, цахилгаан	1,307,150.00
210303	Цэвэр, бохир ус	4,553,138.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	4,161,720.00
210401	Бичиг хэрэг	1,990,520.00
210402	Тээвэр, шатахуун	663,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	787,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	721,200.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	16,397,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,000,000.00
210604	Урсгал засвар	12,397,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	270,928,260.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	269,719,508.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	648,900.00
210807	Газрын төлбөр	19,852.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	297347268.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	297,347,268.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	267,571,345.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	29,775,923.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хөвсгөл аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар нь аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд хүн амын бүлгүүд хүүхэд, залуучууд, гэр бүлийн талаарх төрийн бодлогыг хэрэгжүүлэх, тэдний эрх, хөгжил, хамгааллын ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулах, бодлогын хэрэгжилтийг зохицуулах төрийн захиргааны байгууллага юм.

Тус байгууллага нь 2022 онд 2 зорилтын хүрээнд 46 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж ажилласнаас 90.8 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

#### 3.2 Байгууллагын гадаад дотоод орчин

Байгууллагын үндсэн мэдээлэл, түүний гадаад орчин болон дотоод үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэлийн үйл явцыг судалж, ойлгосноор эрсдэлтэй асуудлыг тодорхойлж баримтжуулав.

Байгууллагад мөрдөгдөх дараах хууль тогтоомжуудад тайлант онд өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

1. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн.
2. Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн “Төрийн хэмнэлтийн тухай” хууль хэрэгжиж эхэлсэн.
3. Төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор тогтоосон ба 2022 оны 192 дугаар тогтоолоор эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг өөрчлөн тогтоосон байна.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ийн дагуу цэцэрлэгийн эрхлэгчийн 2020 оны 06 сарын 30 өдрийн А/62 тоот тушаалаар дотоод хяналт хэрэгжүүлэх ажлын хэсгийг 3 хүний бүрэлдэхүүнтэй баталсан байна. Дотоод хяналтын ажлын хэсэг нь 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулан, тухайн онд нийт 2 удаа дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна. Дотоод хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүр арилгаж ажилласан байна. Харин санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтын 1, 2 үе шатны тогтолцоо бий болсон байна гэж үзлээ. **Тухайлбал:** Санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэх удирдлага буюу эрхлэгч 1 дүгээр гарын үсэг, нягтлан бодогч 2 дугаар гарын үсэг зурж баталгаажуулж байгаа нь гүйцэтгэх удирдлагын хяналтыг хэрэгжүүлж байна. Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Гэр бүл, хүүхэд, залуучуудын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 560.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Дансны авлага	1.8	1.8	-
Бараа материал	40.8	61.1	20.3
Үндсэн хөрөнгө	2,257.4	2,713.8	456.4
Биет бус хөрөнгө	63.0	146.5	83.5
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,363.1</b>	<b>2,923.3</b>	560.2
Дансны өглөг	6.2	78.9	72.7
<b>Эздийн өмч</b>	<b>6.7</b>	<b>79.1</b>	72.4
-төрийн	130.2	208.2	78.0
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,209.9	1,209.9	-
Хуримтлагдсан үр дүн	1,016.3	1,426.1	409.8
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>2,363.1</b>	<b>2,923.3</b>	560.2

Тайлант онд дараах данстад өөрчлөлт орсон байна. Үүнд:

1. Бараа материал данс 20.3 сая төгрөгөөр өссөн нь нэгжийн үйлчилгээний төвд үнэ төлбөргүй ирсэн ариутгалын бодис, нэг цэгийн үйлчилгээнд хүүхдийн тоглоом, тайвшруулах багц, хүүхдийн зөвлөлийн туг, зохион байгуулсан арга хэмжээний хүрээнд хийлгэсэн гэрэлт самбар гэх материал үлдэгдэлтэй байгаагаас шалтгаантай байна.
2. Үндсэн хөрөнгө данс 539.9 сая төгрөгөөр өссөн “Хүүхэд харах үйлчилгээний төв” байгуулахаар сургуулийн байр, 77.5 сая төгрөгөөр сургуулийн газар шилжүүлсэн авсан нь гол нөлөө үзүүлсэн байна.
3. Өр төлбөр данс 72.7 сая төгрөгөөр өссөн нь сургуулийн байрны халаалтын зардлын төсвийг төлөвлөж, батлагүйтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,058.8 сая, нийт зарлагыг 1,058.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас урсгал зардлыг 143.0 сая төгрөгөөр бууруулж, 915.8 сая төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхээр 677.7 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 677.7 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авч, гүйцэтгэл 97.2 хувьтай байгаа ба 19.3 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний зардал

/сая төгрөгөөр/

Хөтөлбөр, арга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
<b>72207</b>	<b>ГБХЗХГазар</b>	<b>677.7</b>	<b>658.4</b>	<b>(19.3)</b>	<b>96.7</b>
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	402.0	386.2	(15.8)	95.3
80236	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	259.5	256.0	(3.5)	98.6
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	16.2	16.2	0	99.4

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд 297.3 сая төгрөгийн нэмэлт орлого хүлээн авч тайлагнасан байна.

Үүнээс байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 5.8 сая төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 16.6 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжид 270.9 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийг Төсвийн тухай хуулийн холбогдох заалтад заасны дагуу орлого хүлээн авч, холбогдох зардлын эрхийг нээлгэж зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хаан Соёмбо Аудит ХХК-ийн аудитор Н.Бадамханд гүйцэтгэж, хяналтыг анхан шатанд Хаан Соёмбо Аудит ХХК-ийн захирал Х.Диймаа, дараагийн шатны хяналтыг ахлах аудитор Б.Давааням, аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,119.9 сая төгрөгөөс 2 хувиар буюу 22.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 буюу 17.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно.

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага 19.3 сая төгрөгийг хэмнэж ажилласан байна.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2022 онд мэдээллийг бүрэн оруулж ажилласан байна.

##### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Хөвсгөл аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2022 оны II улирлын санхүүгийн тайланд завсрын аудит хийж 3 зөвлөмжийг өгсөн байна. Завсрын аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажиллаж алдаа зөрчлийг арилгасан байна.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар байгууллагын бүртгэл, тайлагнал, материалын эмх цэгц, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар 3 зөвлөмжийг өгч, тайлант онд бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	3	139.6	3	139.6	100
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>139.6</b>	<b>3</b>	<b>139.6</b>	<b>100</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар онцгойлон үзэх асуудал байхгүй байна.

## 5. Аудитын илрүүлэлт

Аж ахуйн нэгж, байгууллагуудаас худалдан авалт хийхдээ 3.5 сая төгрөгийн НӨАТ-ын баримтыг аваагүй, баримтын бүрдлийг ханган ажиллаагүй, гэрэл, цахилгааны зардлаас 0.7 сая төгрөгөөр тоолуур худалдан авсан, он дамжсан 1.8 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй, 79.0 сая төгрөгийн өглөг үүссэн нийт 85.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрлээ.

Үүнээс аж ахуйн нэгж, байгууллагуудаас худалдан авалт хийхдээ НӨАТ-ын баримтыг аваагүй, баримтын бүрдлийг ханган ажиллаагүй 3.5 сая төгрөгийн алдааг залруулж, 81.5 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

### 5.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

### 5.3 Албан шаардлага

Албан шаардлага өгөөгүй болно.

### 5.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Дансны үлдэгдэлтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: “Хүүхэд харах үйлчилгээний төв” байгуулахаар 490.0 сая төгрөгийн анхны өртөгтэй барилгыг тайлант онд шилжүүлсэн авсан ч тухайн барилгатай холбоотой ашиглалтын зардлыг төсөвт тусгаагүйгээс 79.0 сая төгрөгийн халаалтын өр үүссэн, он дамжсан 1.8 сая төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дах заалтыг зөрчсөн ба “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж: Авлага, өр төлбөрийг барагдуулж, цаашид өглөг авлага үүсгэхгүй ажиллах.

#### 2. Зарлагын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Гэрэл, цахилгааны зардлаас 0.7 сая төгрөгийн тоолуур худалдан авсан нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг зөрчсөн, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсвийг зардлын эдийн засгийн ангиллын дагуу зарцуулж ажиллах

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

/сая төгрөгөөр/

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Аж ахуйн нэгж, байгууллагуудаас худалдан авалт хийхдээ НӨАТ-ын баримтыг аваагүй, баримтын бүрдлийг ханган ажиллаагүй.зөрүүтэй	1	3.5							1	3.5
Дүн	1	3.5							1	3.5

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант онд ногоон сургуулийн байр ашиглалтад орсонтой холбоотойгоор халаалтын өр үүссэн	1	79.0						79.0				
Он дамжсан авлагыг барагдуулаагүй нь НББ-ийн тухай хуулийг 22.6 зүйл заалт, төсвийн тухай хуулийн 6.4.8 заалтыг зөрчсөн байна	1	1.8					1	1.8				
Гэрэл, цахилгааны зардлаас тоолуур худалдан авсан нь Сангийн сайдын 190 дүгээр тушаалын зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг зөрчсөн.	1	0.7					1	0.7				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>81.5</b>					<b>2</b>	<b>81.5</b>				

**АУДИТЫН ТАЙЛАНГ:**

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:  
 ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
 АНХАН ШАТАНД ХЯНАСАН:  
 АУДИТЫН МЕНЕЖЕР  
 АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

Г.ИЧИНХОРЛОО ОГНОО:

БАТАЛГААЖУУЛСАН:

ХААН СОЁМБО АУДИТ ХХК-ИЙН  
 ЗАХИРАЛ

ЧАНАРЫН ХЯНАЛТ, АХЛАХ АУДИТОР

Х.ДИЙМАА

Н.БАДАМХАНД

